



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 13 өдөр

Дугаар Н22

Бэрх хот

Хүндэтгэл үзүүлж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх заалт, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дах заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралт “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дугаар заалт, Захирагчийн зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн №05 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Бэрх хотын Эмэгтэйчүүдийн анхдугаар чуулга уулзалт 2026 оны 03 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулсантай холбогдуулан зардалд 123.000 төгрөгийг зарцуулсугай.

2. Шаардагдах 123.000 (Нэг зуун хорин гурван мянган) төгрөгийг Захирагчийн нөөц сангаас хууль, дүрэм журмын дагуу гаргаж зарцуулахыг нягтлан бодогч (Г.Осгонжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн албаны дарга (П.Янжмаа)-д даалгасугай.

ЗАХИРАГЧИЙН ЗӨВЛӨЛ
Ч.ЭНХЖАВХЛАН



•232 601 044